

БАТЛАВ

“ДБЭХС” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Г.ОТГОНБААТАР

2020 оны 01 дүгээр сарын 28

**“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК**

**ТӨСЛИЙН НЭР: “Бичиг хэргийн материал худалдан авах, нийлүүлэх”**  
/Үнийн санал авах жишиг баримт бичиг/

**ТӨСЛИЙН ДУГААР: ДБЭХС/202001075**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо : 2020.02.11

Төслийн нэр: **Бичиг хэргийн материал худалдан авах, нийлүүлэх**

Харьцуулалт /гэрээний дугаар: **ДБЭХС/202001075**

**Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем ТӨХК** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“Бичиг хэргийн материал худалдан авах, нийлүүлэх”** цахим тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Дэлгэрэнгүй мэдээлэл болон харьцуулалтын баримт бичгийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж авах ба эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 төгрөг төлснөөр тендер шалгаруулалтанд оролцож болно.

Үнийн саналыг **[2020 оны 02 дугаар сарын 28 ны өдрийн 10:00 цаг]**-аас өмнө **Тендерийн материалыг Худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэрээр ирүүлнэ.**

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 02 дугаар сарын 28** ны өдрийн **[10:15]** -т нээнэ.

Үнийн санал ирүүлэхдээ барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсарган ирүүлнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Цахим худалдан авах систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээс үнэ төлбөргүй татаж авна уу.

*Дорнод аймаг, Хэрлэн сум, 1-р баг*  
“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн төв байр  
Утас: 70584545, 99043832, 99042997

---

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа	1.1.	Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт	2.1.	Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
	2.2.	Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл	3.1.	<p>Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</p> <p>(а) Үнийн санал /Тендерийн маягт/;</p> <p>(б) Үнийн болон бараа нийлүүлэлтийн хуваарь;</p> <p>(в) Тендерт оролцогчийн эрх бүхий болох тухай мэдэгдэл,</p> <p>(г) Санал болгож буй бичиг хэргийн материал нь захиалагчаас тогтоосон техникийн шаардлагыг хангаж буйг нотолсон баримт бичиг, техникийн дэлгэрэнгүй үзүүлэлт, фото зургийн хамт ирүүлэх шаардлагатай,</p>
4. Тогтмол үнэ	4.1.	Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд	5.1.	Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
	5.2.	Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа	6.1.	Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>45</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх	7.1.	Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
	7.2.	Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <b>ТШӨХ-д</b> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
	7.3.	Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ  
байгуулах эрх  
олгох тухай  
мэдэгдэл**

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.
-

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТӨӨЗ 1.1</b>	<p>Сүүлийн нэг жилийн хугацаанд гүйцэтгэсэн хэмжээ болон үнийн дүнгээр ойролцоо ижил төстэй ажил гүйцэтгэсэн тухай туршлагын талаарх мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, хүлээлцсэн актын хамт/;</p> <p>Бусад нэмэлт шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Аж ахуй нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар,</li> <li>- Санал болгож буй бичиг хэргийн материалыг жилийн турш гэрээгээр тухай бүрд захиалгын дагуу богино хугацаанд бэлтгэн нийлүүлэх тухай албан бичгээр баталгаа ирүүлэх.</li> <li>- Багц №1-ийг зөвхөн дотоодын үйлдвэрт үйлдвэрлэгдсэн бараа материал авна.</li> <li>- Санал болгож буй материалын үйлдвэрлэгчийн нэр, стандартыг тодорхой ирүүлэх.</li> </ul>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:  <b>2020 оны 02 дугаар сарын 28 өдөр 10:00 минут</b>  Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Mb-аас ихгүй байна, нэг файлын хэмжээ 15 Mb-аас ихгүй байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.</p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>[Дорнод аймаг, Хэрлэн сум, 1-р баг ]</b>.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>[“ДБЭХС” ТӨХК төв байр , 2 давхар 201 тоот, Сургалтын танхим]</b>.</p> <p>Огноо: <b>[2020 оны 02 дугаар сарын 28-ны өдөр]</b></p> <p>Цаг: <b>[10 цаг 15 минут]</b></p> <p><b>Тодруулга авах утас: 99043832, 99042997</b></p>

**Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, БАРАА НИЙЛҮҮЛЭЛТ**

1. **Барааны тодорхойлолт:** *[Бичиг хэргийн материал нийлүүлэх ажлыг гүйцэтгэхэд уг тодорхойлолтыг мөрдлөг болгоно. Хэвлэмэл журналын загварыг баталгаажуулсан хувийг авах, ажлын талбайтай биеэр танилцах].*
2. **Бараа хүргэх газар:** *[Дорнод аймаг, Хэрлэн сум, “ДБЭСХ” ТӨХК-н төв агуулах].*
3. **Үйлчилгээ үзүүлэх газар:** Цэнэглэсэн хор буюу хор цэнэглэх үйлчилгээг тухайн алба, хэлтэс, цех, салбарт хүрч үзүүлнэ.
4. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:** [Гэрээ байгуулагдсанаас хойш **Багц №1-ийг 30** хоногийн дотор, **Багц №2, Багц №3-ийг** захиалагчийн сар бүрийн захиалгын дагуу нийлүүлэх ба эцсийн материал нийлүүлэх хугацаа **2020** оны **12** сар **20** хүртэл].



ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

БАТЛАВ

Ө.ЖАРГАЛСАЙХАН



## БИЧИГ ХЭРГИЙН МАТЕРИАЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2020.01.27

Хэрлэн сум

№	Үзүүлэлт	Тавигдах шаардлага
1	Бичгийн цаас А4	80 гр, цаасны нягтрал сайтай, зузаан, Double A дүйцэхүйц.
2	Бичгийн цаас А3	Цаасны нягтрал сайн, чанартай.
3	Принтерийн хор /өнгөт, цэнэглэдэг/	1200-2800 хуудас хэвлэх, 3-4 цэнэглэх
4	Журналууд	Бэлтгэсэн эхийн дагуу А3 цаасыг нугалж А4 болгосон байх ба өнгөт нүүр хуудастай, А4 фото цаасаар гадарласан, 50 хуудас.
5	Наряд хуудас	А4 хэмжээтэй, тод харагдахуйц байх.
6	Техникийн паспорт	Батлагдсан маягтын дагуу.
7	Короно хавтас	Нэмэлт дарлагатай, 2 сэрээ бүхий Deli-тэй дүйцэхүйц, чанарын шаардлага хангахуйц.
8	Нүхтэй уут	Зузаан, чанарын шаардлага хангахуйц.
9	Хавтас /10-100 хуудастай/	Deli-тэй дүйцэхүйц, чанарын шаардлага хангахуйц.
10	Баримтын бор хавтас	Шаргал өнгөтэй, зузаан, маркераар бичихэд баалж уудаггүй байх.

ХЯНАСАН:

ХҮХ-ИЙН ДАРГА

А.ТӨГСМАНДАХ

БОЛОВСРУУЛСАН:

МАТЕРИАЛЫН НЯ-БО  
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН  
АЖИЛТАН

М.ӨЛЗИЙ-ОРШИХ

Л.ЭРДЭНЭЦЭЦЭГ



## Тав. ЖИШИГ МАЯГТ

## 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээсэн өдрөөс хойш [45] хоногийн хугацаанд хүчинтэй байна.
3. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Техникийн тодорхойлолт, үзүүлэлт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

### Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |       |  |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[байхгүй]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[14]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |  |  |
|--|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1)                             | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]  |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li> <li>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;</li> <li>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</li> <li>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;</li> <li>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li> <li>6) Захиалагч талаас өгсөн захиалгын хуудас, нийлүүлэгчийн зарлагын падаан, нэхэмжлэхийг хамт ирүүлэх</li> </ol> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5)                                  | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>[Захиалагч талын чанарын шаардлагад нийцэхгүй гэж үзсэн бараа материалыг нийлүүлэгч тал үл маргах журмаар шаардлагад нийцсэн бараа материалаар нэн даруй сольж өгнө]</p>   |
| 4. Төлбөр (ГЕН – 7)  | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн <b>100</b> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p>   |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)                              | <p>9.1. Алданги оногдуулах хувь: хугацаа хэтэрсэн хоног тутамд гэрээний үнийн дүнгийн <b>[0.5] хувь</b></p> <p>Алдангийн нийт дүн: Гэрээний нийт үнийн <b>[10] хувиас</b> хэтрэхгүй.</p>   |
-

## Найм. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>1</sup>

### БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

### [Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>2</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>1</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>2</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГДЭХ БИЧИГ ХЭРГИЙН МАТЕРИАЛЫН  
ТӨРӨЛ, НИЙЛҮҮЛЭХ ХУГАЦАА**

2020.01.27

Д/д	Барааны тодорхойлолт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
<b><i>Бичгийн цаас, хавтас, журнал</i></b>			
<b>Багц №1</b>	1	Зааварчилгааны журнал	ширхэг 95
	2	Наряд хуудас	ширхэг 700
	3	Ажиллагааны журнал	ширхэг 380
	4	Цаг бүртгэлийн журнал	ширхэг 13
	5	Тогтоолын журнал	ширхэг 50
	6	ХХ-ын үзлэгийн журнал	ширхэг 16
	7	Гэмтлийн журнал	ширхэг 27
	8	Рапортын журнал	ширхэг 30
<b>Багц №2</b>	1	Бичгийн цаас /А4/	боодол 710
	2	Бичгийн цаас /А3/	боодол 10
	3	Техникийн пасспорт	ширхэг 270
	4	Короно хавтас	ширхэг 79
	5	Нүхтэй уут	ширхэг 1,700
	6	Баримт үдэх бор хавтас	ширхэг 350
	7	Хавтас 10 хуудастай	ширхэг 32
	8	Хавтас 20 хуудастай	ширхэг 211
	9	Хавтас 30 хуудастай	ширхэг 116
	10	Хавтас 40 хуудастай	ширхэг 185
	11	Хавтас 60 хуудастай	ширхэг 101
	12	Хавтас 80 хуудастай	ширхэг 11
	13	Хавтас 100 хуудастай	ширхэг 6
<b>Багц №3</b>	1	<b><i>Принтерийн хор</i></b>	
	2	Принтерийн хор	ширхэг 90
	3	Принтерийн хор /өнгөт/	ширхэг 16
	4	Принтерийн хор /цэнэглэдэг/	ширхэг 110

Бараа нийлүүлэлт буюу **Багц №1-ийг** гэрээ байгуулсанаас хойш **30** хоногийн дотор нийлүүлэх ба **Багц №2** болон **Багц №3-г** худалдан авагч талын сар бүрийн захиалгын дагуу **2020** оны **12** дугаар сарын **20** ны өдөр хүртэл нийлүүлнэ.